

**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**МЕТАЛЛЫН ШАЛГАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ БОДИС, МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

Төслийн дугаар:

**МЕТАЛЛЫН ШАЛГАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ БОДИС,
МАТЕРИАЛ
ХА-37-2020**

ДЦС-3

Улаанбаатар хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ДЦС-3” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Металлын шалгалт, шинжилгээний бодис материал нийлүүлэх” тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 03-р сарын 17-ны өдрийн 10.00 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 03-р сарын 17-ны өдрийн 10:05-д** цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: тооцохгүй
Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.
Веб хуудас: www.tes3.energy.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн жилийн санхүүгийн тайлан ирүүлэх. (Аудитаар баталгаажуулсан байх) 2. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн туршлагын мэдээлэл (Сүүлийн нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй материал нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актны хуулбар) 3. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. 4. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар 5. Аж ахуйн нэгжийн товч танилцуулга 6. Татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй. Тендер нээсэн өдрөөр цахим системээс татаж шалгана. 7. Харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт. (Өргүй байх) 8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт 10. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын тодорхойлолт 11. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй гэсэн тодорхойлолт ирүүлэх 12. Тендерийн маягтын дагуу барааны үнийн хуваарь ирүүлэх 13. Бараа нийлүүлэх хувиарийг маягтын дагуу ирүүлэх 14. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлнэ. 15. Нийлүүлэх барааны зураг танилцуулга монгол хэлээр бэлтгэж ирүүлэх
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn</p> <p>Огноо:2020 оны 03-р сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендер нээлт хийх газар хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот</p> <p>Огноо:2020 оны 03-р сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 05 минут</p>
ТӨӨЗ 5.1	Техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар ирүүлэх
ТӨӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

Дөрөв. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

д/д	Нэр	Тодорхойлолт (тип марка)	Тоо ширх эг	Хэмж их нэгж	ТШӨ Х-д заасан барааг хүргэх эцсий н цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүү лэгчи йн санал болгос он хугаца а
0	1	2	3	4	5	6	7	8
1	Глицерин хэт богино авианы, цэвэр	эмнэлгийн	80	кг	<i>ДЦС-3 ТӨХК- ний хашаа агуула х</i>	-	2020.4.30	-
2	Дулаан боловсруулалтын аппаратны температурын контролёр проксиметр	Bentley Nevada 8 mm P/N330100-90-00	5	ком	-	-	2020.4.30	-
3	Дулаан боловсруулалтын эсэргүүцлийн шаазан индуктор	2.7kW, 60V	48	ком	-	-	2020.4.30	-
4	Металлографийн шинжилгээний сорьц таслагч универсаль машин	2800эргэлт/мин 1,1кВт-аас доошгүй	1	ком	-	-	2020.4.30	-
5	Металлографийн шинжилгээний сорьц бэлтгэх шахагч аппарат	220V, 650W	1	ком	-	-	2020.4.30	-
6	Нарийн зүлгүүр /D250 мм, металлографийн стандартын ширхэглэл, техникийн өгөгдлийн дагуу/	Silicon carbide paper	100	ш	-	-	2020.4.30	-
7	Протакрил дихлорэтан	VersoCit-2 ClaroCit	10	хайр	-	-	2020.4.30	-
8	Соронзон нунтгийн өөрөө флуоресценцлэгч бодис	Circle Systems Mi-Glow 418	24	ком	-	-	2020.4.30	-

9	Фазлагдсан матрицын Doppler багажны тусгай батарей болон цэнэглэгч адаптер	Li204SX Model No5 SPU63-106	1	Ком	-	-	2020.4.30	-
10	Гэм согог илрүүлэгч багажны хэмжигч толгой	Euro integral beam probe	20	ком	-	-	2020.4.30	-
11	Гэм согог илрүүлэгч багажны толгойны холбогч кабель	Euro standard	20	ком	-	-	2020.4.30	-
12	Цэмбэн зүлгүүр /металлграфийн шинжилгээний стандарт, техникийн өгөгдлийн дагуу/	MD-Cloths DP/OP-Cloths	9	м	-	-	2020.4.30	-
13	Шингэн нэвчүүлэх шалгалтанд хэрэглэгдэх бодисууд	KO-17 HI-TEMP Cleaner Penetrant Developer	16	ком	-	-	2020.4.30	-
14	Ган хайлах индукцийн зуухны сэлбэг	steel melting induction furnace	1	Ком	-	-	2020.4.30	-
15	Фазлагдсан матрицын Doppler багажны толгой 7.5Mhz	Cobra probe 7.5MHz	1	Ком	-	-	2020.4.30	-
16	Фазлагдсан матрицын Doppler багажны толгой 5.0Mhz	PA Probe 5MHz	1	Ком	-	-	2020.4.30	-
17	Дулаан боловсруулалтын индуктор /уян/	Зэс голтой, уян	20	М	-	-	2020.4.30	-
18	Металлографийн өнгөлгөөний паст гой	DP paste	4	Кг	-	-	2020.4.30	-

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Техникийн ерөнхий шаардлага

Нийлүүлэгч нь тендерийн бичиг баримтанд нийлүүлэх металлын шалгалт шинжилгээ, дулаан боловсруулалтын болон үл эвдэх сорилтын сэлбэг материал, бодисны үйлдвэрлэгчийн дараах бичиг баримтуудыг заавал хавсаргана. Үүнд:

- Нийлүүлэх үйлдвэрлэгчийн тамга тэмдэг бүхий баталгаат албан бичиг /захиалагчид хаягласан, нийлүүлэгчтэй холбоотойг гэрчлэх/
- Тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны танилцуулганы эх хувь /тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болохыг нотлох/
- Тухайн үйлдвэр нь албан ёсны үйл ажиллааны вэб хуудастай байх
- Тендерийн бичиг баримт ирүүлэхдээ тухайн нийлүүлэх металлын шалгалт шинжилгээ, дулааны боловсруулалт, үл эвдэх сорилтын сэлбэг материал, бодис тус бүрийн танилцуулга, техникийн нарийвчилсан үзүүлэлт, зургийг заавал хавсаргасан байна.

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн байна.

Д.д	Материалын нэр	Төрөл	Техникийн тодорхойлолт
1	Цэвэр глицерин	эмнэлгийн	Цэвэр, эмнэлгийн, тунгалаг цагаан өнгөтэй, өтгөн /хэт авианы шалгалтанд тохирох/
2	Дулаан боловсруулалтын аппаратны температурын контролёр проксиметр	P/N330100-90-00 төрлийн	Bentley Nevada 8 mm P/N330100-90-00 Vt 24VDC, 200mV/ml /7.87V/ml /mm/ (Controller BTC9100 type for TF-8056 machine)
3	Дулаан боловсруулалтын индуктор /шаазан/	2.7kW, 60V	Чадал нь 60kW, 380V, 400A, Керамик шаазан нь 98%-ийн хөнгөнцагааны оксидын агуулгатай, Эсэргүүцлийн халаагч утас нь 85%Ni, 15%Cr-ын агуулгатай
4	Металлографийн шинжилгээний сорьц таслагч универсаль машин	2800эргэлт/мин 1,1кВт-аас доошгүй	Таслах дискний хэмжээ: 250x2x32мм Эргэлтийн хурд: 2800эргэлт/мин Хүчдэл: 220В/38В, 50Гц Жин: 60кг-ээс доошгүй
5	Металлографийн шинжилгээний сорьц бэлтгэх шахагч аппарат	220V, 650W	Сорьц бэлтгэх диаметр: Ф22, Ф30, Ф45 Халаагчийн үзүүлэлт: 220В, 650Вт Халаах температур: 150С Жин: 30кг-ээс доошгүй
6	Нарийн зүлгүүр /D250 мм, металлографийн стандартын ширхэглэл, техникийн өгөгдлийн дагуу/	Silicon carbide paper	P60, P80, P120, P220, P360, P800, P1200, P2400, P4000
7	Протакрил дихлорэтан /металлографийн сорьц бэлтгэх эпоксид смола төрлийн хатууруулагч бодис/	VersoCit-2	Өнгө-ягаавтар, Холих хэмжээ -1% шингэн:2%нунтаг, Холих хугацаа-30сек, Бэхжих хугацаа-10мин, Нурах хугацаа-3мин, Оргил температур-100°С, Хатуулаг 82.
		ClaroCit	Өнгө-тунгалаг, Холих хэмжээ -1% шингэн:2%нунтаг, Холих хугацаа-90сек, Бэхжих хугацаа-20мин, Нурах хугацаа-90сек, Оргил температур-75°С, Хатуулаг 84.

8	Соронзон нунтагийн өөрөө флуоресценцлэгч бодис	Circle Systems Mi-Glow 418	Усан суурьтай, хар-ногоон өнгөтэй, UV-A гэрэлд ялгарч харагддаг байх, ASTM-E709, ASTM-E1444 стандартыг хангасан байх, Бөөмийн хэмжээ-5µm, AMS стандарт 3044, SAE мэдрэмж-8, Температурын хязгаар 0-149°C, Нэг иж бүрдэлдээ галлоноос доошгүй байх
9	Фазлагдсан матрицын Doppler багажны тусгай батарей болон цэнэглэгч адаптер	Li204SX Model No5 SPU63-106	Li-ion battery Li204SX, DC10,8V, 7800mAh, 84.24Wh Switching power supply Model No5 SPU63-106 Input100-240V, 47-63Hz, Output 15V, 4.2A
10	Гэм согог илрүүлэгч багажны хэмжигч толгой	Euro integral beam probe	2C8*9A45, 2C8*9A60, 2C8*9A70, 4C8*9A45, 4C8*9A60, 4C8*9A70,
11	Гэм согог илрүүлэгч багажны толгойны холбогч кабель	Euro standard	Q9-Q9, Q9-L5, C9-C5 төрөл тус бүрээс
12	Цэмбэн зүлгүүр /металлграфийн шинжилгээний стандарт, техникийн өгөгдлийн дагуу/	MD-Cloths DP/OP-Cloths	MD/DP-Plan, MD/DP-Sat, MD/DP-Dur, MD/DP-Mol, MD/DP-Plus, OP-Nat, OP-Felt, MD/OP-Chem, MD/OP-NonStick төрлийн цэмбэ, даавуун металлографийн зориулалтын зүлгүүр
13	Шингэн нэвчүүлэх шалгалтанд хэрэглэгдэх бодисууд	KO-17 HI-TEMP Cleaner Penetrant Developer	Нэг иж бүрдэлдээ: MIL-1-25135, AMS-2644, ASTM E-1417 стандартын шаардлагыг хангах ёстой. Пенетрант нь 180°C температурт тэсвэртэй байх, флуоресценцлэгч чанартай байх. Цэвэрлэгч, пенетрант, тодруулагч тус бүр нь нэг иж бүрдэлдээ галлоноос доошгүй байх
14	Металл хайлах индукцийн зуухны сэлбэг	steel melting induction furnace	50 кг-ийн ган хайлах индукцийн зуухны хайлах тогооны материал сэлбэгүүд
15	Фазлагдсан матрицын Doppler багажны толгой 7.5Mhz	Cobra probe 7.5MHz	7.5S32-0.5*10-D10-U-110-2.0 7.5MHz, 32 elements, Pitch-0.5mm, Aperture-8mm, Elevation-10mm, casing dimensions 25x22x10. For match to Doppler PHASCAN 16/64 phased array flaw detector.
16	Фазлагдсан матрицын Doppler багажны толгой 5.0Mhz	PA Probe 5MHz	5L64-1.0*10-U10-110-2.0-T1 5MHz, 64 elements, Pitch-1.0mm, Aperture-64mm, Elevation-10mm, casing dimensions 21x28x22. For match to Doppler PHASCAN 16/64 phased array flaw detector.
17	Дулаан боловсруулалтын индуктор /уян/	Зэс голтой, уян	Дотор талдаа уян аустенит ган хоолой бүхий голтой, хоолойн гадуур зэс ороомогтой, ороомгийн гадуур зориулалтын карборундум фибр болон асбостекло дулаалга бүхий 4 давхарга бүхий, 1500°C хүртэл индукцийн аргаар халаах зориулалттай уян индуктор
18	Металлографийн өнгөлгөөний паст гой	DP paste P	Поликристалл алмазан нунтаг бүхий паст Мөхлөгийн хэмжээ нь 1µm, 3µm, 6µm, 9µm, 15µm, Поликристалл алмазан пас DP paste P мөхлөг төрөл тус бүрээс
		DP paste M	Поликристалл алмазан нунтаг бүхий паст Мөхлөгийн хэмжээ нь 1µm, 3µm, 6µm, 9µm, 15µm, Поликристалл алмазан пас DP paste M мөхлөг төрөл тус бүрээс

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“ДЦС-3” ТӨХК-ын дарга Ч.Чинбат танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч ИТА барааг хүлээн авч акт бүрдүүлнэ. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа шаардахгүй. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн 0,3 хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн 30%-аас хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу захиалагч холбогдох ИТА нар хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан зарлагын падаан, нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 3.1 Баталгаат засварын тусгай шаардлага: Баталгаат хугацаа 12 сар.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 4.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Захиалагч барааг гүйцэт хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулсны дараа нийлүүлэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн **30** хоногийн дотор шилжүүлнэ.
- 4.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 5.1 Алданги оногдуулах хувь: **0,3**
- Алдангийн нийт дүн: **30 %-аас хэтрэхгүй**

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
...../Ч.ЧИНБАТ/

БАТЛАВ
“.....” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
...../...../

..... ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2019 оны дугаар
сарын.....ны өдөр

№.....

Улаанбаатар хот

Ерөнхий зүйл

Нэг талаас “Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж нөгөө талаас “.....” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/-ийг төлөөлж нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, “Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” ТӨХК-ийн тоот шийдвэр, Зөвлөмж, 2019 оны бизнес төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь/цаашид “бараа” гэх/-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу DDP-Улаанбаатар “ДЦС-3” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр нийлүүлнэ.

Хоёр. Нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурснаас хойш хоногийн дотор нийлүүлнэ.

Гурав. Үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ /үсгээр/ төгрөг бөгөөд үнийн дүнд гааль, онцгой татвар, УБ “ДЦС-3” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй. Захиалагч барааг бүрэн хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулсны дараа нийлүүлэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн 30 хоногийн дотор шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгчийн буруугаас бараа нийлүүлэх гэрээнд заасан хугацааг хожимдуулснаас тоноглолын засварын хугацааг сунгах, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулах, хязгаарлахад хүрсэн бол үүнээс үүдэн гарсан хохирлыг Нийлүүлэгч нь Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

4.2 Нийлүүлэгч нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид хоног тутам төлөх ба гэхдээ нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Захиалагч нь Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.3 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараах төлбөрийн хугацааг хожимдуулбал төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Нийлүүлэгч нь Захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

4.4 Нийлүүлэгч нь гэрээг хэсэгчлэн болон бүрэн биеллээгүй тохиолдолд энэхүү гэрээний 4.1 ба 4.2-т заасан хариуцлагаас Нийлүүлэгчийг чөлөөлөхгүй.

4.5 Гэрээний үүргийг бүрэн болон хэсэгчлэн биеллээгүй тохиолдолд бараа материалын үнийн дүнгээс үл хамаарч гүйцэтгэлийн баталгаа олгохгүй. Энэ нь алдангиас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Тав. Бараа, бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодол

5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол Улсын стандарт, техникийн нөхцөл шаардлагыг бүрэн хангасан байна.

5.2 Нийлүүлэх бараа нь 2018 оноос хойш үйлдвэрлэсэн, хадгалалтын үед хийгдэх үйлчилгээ хийгдсэн байх, баталгаат хугацаа ашиглаж эхэлснээс хойш байна.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

- 5.3 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс бүрэн хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.4 Барааг Захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд мөн чанараа алдахгүй байх ёстой.
- 5.5 Нийлүүлсэн барааны чанарт ямар нэг дутагдал илэрвэл түүнийг засах, сольж өгөхийг Захиалагч шаардах ба Нийлүүлэгч уул шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.6 Барааны баглаа, боодол дараах байдлаар хаяглагдсан байна.
 - Гэрээний дугаар
 - Барааны нэр
 - Хүлээн авагчийн хаяг
 - Ачаа илгээгч
- 5.7 Барааг дараах бичиг баримт дагалдана.
 - Савлалтын хуудас 3 хувь
 - Чанарын гэрчилгээ 3 хувь
 - Барааны гарал үүслийн гэрчилгээ 3 хувь

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

- 6.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн буюу бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль ч хариуцлага хүлээхгүй.
- 6.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөлдөнө.

Долоо. Гэрээг цуцлах журам

- 7.1 Нийлүүлэгч нь бараа нийлүүлэх хугацааг энэхүү гэрээнд зааснаас 14 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээ цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч нь гэрээг дангаар цуцлана.
- 7.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Найм. Бусад нөхцөл

- 8.1 Талууд аль нэг нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 8.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 8.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж Захиалагч 2 хувийг, Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 8.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 8.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.
- 8.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн аливаа оруулга, засвар, нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 8.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.
- 8.8 Тендерийн баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно.
Энэхүү гэрээ нь үндсэн 3 хуудас, хавсралт 2, хуудас нийт 5 хуудаснаас бүрдэнэ.

Ес. Талуудын хаяг:

Захиалагчийн хаяг:

Хан-Уул дүүрэг, 3-р хороо
 “ДЦС-3” ТӨХК-ийн байр
 Утас: 341990, 344111
 Регистр: 2546191
 Банк:
 Төгрөгийн данс:

Нийлүүлэгчийн хаяг:

.....

 Утас:
 Регистр:.....
 Банк:
 Төгрөгийн данс:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДЦС-3” ТӨХК-ИЙН

 /...../

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ИЙН

 /...../